



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Жаргалант сумын 7 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/131/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Ц.Бадрал

Утас: 91983443

цахим хаяг: Badralts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	14
3.5.3 Нэмэлт төсөв.....	15
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН 7 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ц.АЛТАНТУНГАЛАГ ТАНАА

2023.02.10 № 02/62

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Жаргалант сумын 7 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Жаргалант сумын 7 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр гэрээний дагуу 5 ширхэг зөөврийн компьютер, 1 ширхэг ухаалаг самбарын үнэ 25.6 сая төгрөгийг шилжүүлэн цахим худалдан авалт хийснээс хөрөнгө ирээгүй авлагаар бүртгэсэн, цахим хуудас хийлгэхэд урьдчилгаанд 0.5 сая төгрөг, мөн татварын авлага 4.0 сая төгрөг илүү тооцон шилжүүлж авлага үүссэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант хугацаанд Боловсрол шинжлэх ухааны газраас 11.0 сая төгрөгийн тавилга, сурах бичиг, түрээсийн сурах бичиг, Боловсролын мэдээллийн технологийн төвөөс 1.3 сая төгрөгийн сүлжээний тоног төхөөрөмж, боловсрол шинжлэх ухааны яамнаас 17.4 сая төгрөгийн ном ариутгагч, Жаргалант сумын орон нутгийн хөгжлийн сангаас 44.8 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, сургуулийн үйлдвэрчний эвлэлээс өрөө тохижуулахад 2.3 сая төгрөгөөр тавилга, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газраас 2.4 сая төгрөгийн номыг тус тус үнэ төлбөргүйгээр, 78.1 сая төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч, батлагдсан төсвийг 169.4 сая төгрөгийг хэмнэжээ.

Бусад асуудлын хэсэг

Тус сургууль нь 320 хүүхэд хүлээн авах хүчин чадалтайгаас 2022 онд 46 бүлэгт 1456 хүүхэдтэйгээр, 63 багштай, 111 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

2022 онд 15 зорилт 79 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, биелэлтийг тооцон Жаргалант сумын Засаг даргад хүргүүлжээ.

021020235

2022 онд хийсэн багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр II түвшний багш -1, III түвшний багш -1, IV түвшний багш 2 шалгагдсан байна.

2022 онд дотуур байранд 94 хүүхэд амьдарч хоолны зардалд 16377 хүүхэд өдөр 56.9 сая төгрөг, үдийн хоолонд бага ангийн 22 бүлэгт 112,210 хүүхэд өдөр суралцаж үдийн хоолны зардалд 167.1 сая төгрөгийг зарцуулжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



X. Баянбаатар Х.БАЯНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	138,304,236.75	452,450,295.16
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		263,852,109.85
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		263,852,109.85
3121	Төгрөг		263,852,109.85
31211	Төрийн сангийн харилцах		263,852,109.85
33	АВЛАГА	13,599,463.00	29,633,210.00
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	599,463.00	4,001,210.00
335	Бусад авлага	13,000,000.00	25,632,000.00
3351	Байгууллагаас авах авлага	13,000,000.00	25,632,000.00
34	УРЬДЧИЛГАА		500,000.00
346	Урьдчилж гарсан зардал		500,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	124,704,773.75	158,464,975.31
351	Түүхий эд материал	5,023,078.00	3,060,800.00
3513	Эм боох материал	5,023,078.00	3,060,800.00
354	Хангамжийн материал	119,681,695.75	155,404,175.31
3542	Аж ахуйн материал	4,582,456.00	19,565,630.00
3544	Түлш, шатах тослох материал	1,605,000.00	3,822,000.00
3546	Хүнсний материал	458,370.00	1,055,800.00
3547	Бусад хангамжийн материал	113,035,869.75	130,960,745.31
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,964,562,587.70	4,957,666,355.46
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,964,562,587.70	4,957,666,355.46
392	Биет хөрөнгө	4,734,162,587.70	4,727,266,355.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,780,682,840.68	4,780,682,840.68
39202	Хуримтлагдсан элэгдэл	-296,714,459.84	-415,060,403.60
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	243,922,693.72	357,760,431.72
39206	Хуримтлагдсан элэгдэл	-192,863,004.65	-220,374,878.10
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	198,740,398.81	231,150,436.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	-72,085,246.03	-90,478,347.08
39214	Бусад үндсэн хөрөнгө	72,479,365.01	83,586,275.41
393	Биет бус хөрөнгө	230,400,000.00	230,400,000.00
39301	Програм хангамж	18,400,000.00	18,400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-18,400,000.00	-18,400,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	230,400,000.00	230,400,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,102,866,824.45	5,410,116,650.62
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,102,866,824.45	5,410,116,650.62
51	Засгийн газрын хувь оролцоо	5,102,866,824.45	5,410,116,650.62
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,523,546,409.40	1,523,546,409.40
51101	Өмч: - төрийн	1,523,546,409.40	1,523,546,409.40
512	Хуримтлагдсан үр дүн	2,424,033,497.59	2,731,283,323.76
5121	Өмнөх үеийн үр дүн	2,424,033,497.59	2,424,033,497.59
5122	Тайлант үеийн үр дүн		306,749,826.17
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,155,286,917.46	1,155,286,917.46

VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,102,866,824.45	5,410,116,650.62
----	--	------------------	------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,847,400,417.04	2,691,980,626.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,080,161.04	111,162,768.38
120	Нийтлэг татварын бус орлого	31,080,161.04	111,162,768.38
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	31,080,161.04	107,787,768.38
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		10,355,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	30,480,161.04	97,432,068.38
120009	Бусад орлого		3,375,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,816,320,256.00	2,580,817,858.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,541,083,900.00	2,299,253,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,541,083,900.00	2,299,253,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	108,783,836.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	108,783,836.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	166,399,800.00	281,074,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	166,399,800.00	281,074,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	52,720.00	489,458.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	52,720.00	489,458.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,953,518,481.78	2,384,730,800.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,953,518,481.78	2,384,730,800.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,812,555,157.78	2,216,636,102.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,265,160,820.00	1,540,334,271.33
210101	Үндсэн цалин	854,600,699.00	1,120,332,447.33
210102	Нэмэгдэл	337,573,121.00	357,123,936.00
210104	Урамшуулал	72,987,000.00	62,877,888.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	163,658,417.00	190,906,251.82
210201	Тэтгэврийн даатгал	115,075,973.53	130,388,843.86
210202	Тэтгэмжийн даатгал	12,793,090.19	15,520,006.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,227,752.30	12,416,003.64
210204	Ажилгүйдлийн даатгал	2,323,782.16	2,821,627.04
210205	Эрүүл мэндийн даатгал	23,237,818.82	29,759,770.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	158,192,284.00	180,172,260.00
210301	Гэрэл, цахилгаан	21,010,300.00	31,470,760.00
210302	Түлш, халаалт	115,034,500.00	117,350,000.00
210303	Цэвэр, бохир ус	22,147,484.00	31,351,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,911,666.00	
210401	Бичиг хэрэг	782,700.00	

210402	Тээвэр, шатахуун	172,600.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,235,910.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	478,406.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,242,050.00	
2105	Нормативт зардал	34,340,803.00	59,691,379.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,628,800.00	2,814,058.00
210502	Хоол, хүнс	24,936,153.00	56,877,321.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,775,850.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,174,800.00	6,983,000.00
210604	Урсгал засвар	5,174,800.00	6,983,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,844,000.00	13,570,050.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,836,000.00	7,690,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		5,879,350.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	167,272,367.78	224,978,890.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	392,200.00	50,035,971.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,612,141.00	10,692,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	154,268,026.78	164,250,918.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	140,963,324.00	168,094,698.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	140,678,858.00	167,581,958.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	52,720.00	489,458.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	46,557,850.00	167,092,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	91,743,288.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,325,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	284,466.00	512,740.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	284,466.00	512,740.00
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Дотоод эх үүсвэрээр		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-106,118,064.74	307,249,826.17
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	935,775.28	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	935,775.28	
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-935,775.28	
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-107,053,840.02	307,249,826.17

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,816,920,256.00	2,594,548,558.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	600,000.00	13,730,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	600,000.00	13,730,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	600,000.00	10,355,700.00

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	10,355,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	-
120009	Бусад орлого	-	3,375,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,816,320,256.00	2,580,817,858.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,541,083,900.00	2,299,253,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,541,083,900.00	2,299,253,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	108,783,836.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	108,783,836.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	166,399,800.00	281,074,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	166,399,800.00	281,074,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	52,720.00	489,458.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	52,720.00	489,458.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,816,920,256.00	2,330,696,448.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,816,920,256.00	2,330,696,448.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,678,281,932.00	2,162,601,750.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,259,399,700.00	1,543,756,252.00
210101	Үндсэн цалин	854,468,900.00	1,123,754,428.00
210102	Нэмэгдэл	331,943,800.00	357,123,936.00
210104	Урамшуулал	72,987,000.00	62,877,888.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	170,019,000.00	190,886,018.15
210201	Тэтгэврийн даатгал	119,643,000.00	130,368,610.19
210202	Тэтгэмжийн даатгал	12,594,100.00	15,520,006.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,075,100.00	12,416,003.64
210204	Ажилгүйдлийн даатгал	2,518,800.00	2,821,627.04
210205	Эрүүл мэндийн даатгал	25,188,000.00	29,759,770.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	161,363,284.00	182,389,260.00
210301	Гэрэл, цахилгаан	21,010,300.00	31,470,760.00
210302	Түлш, халаалт	118,205,500.00	119,567,000.00
210303	Цэвэр, бохир ус	22,147,484.00	31,351,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,662,948.00	-
210401	Бичиг хэрэг	1,484,520.00	-
210402	Тээвэр, шатахуун	172,600.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,122,200.00	-
210404	Ном, хэвлэл	558,500.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,316,928.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,008,200.00	-
2105	Нормативт зардал	34,721,900.00	57,474,751.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,958,800.00	-
210502	Хоол, хүнс	25,417,700.00	57,474,751.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,345,400.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,143,000.00	6,983,000.00
210604	Урсгал засвар	6,143,000.00	6,983,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,448,000.00	26,076,770.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,440,000.00	8,700,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		17,376,070.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,524,100.00	155,035,699.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,600,000.00	128,940,099.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,924,100.00	26,095,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	138,638,324.00	168,094,698.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	138,353,858.00	167,581,958.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	52,720.00	489,458.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	46,557,850.00	167,092,500.00

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	91,743,288.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	284,466.00	512,740.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	284,466.00	512,740.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		263,852,109.85
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		263,852,109.85
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	263,852,109.85

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,523,546,409.40	1,155,286,917.46	2,531,087,337.61	5,209,920,664.47
2	Тайлант үеийн үр дүн			-107,053,840.02	-107,053,840.02
3	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,523,546,409.40	1,155,286,917.46	2,424,033,497.59	5,102,866,824.45
4	Тайлант үеийн үр дүн			307,249,826.17	307,249,826.17
5	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,523,546,409.40	1,155,286,917.46	2,731,283,323.76	5,410,116,650.62

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,590,684,100.00	2,326,319,250.15	264,364,849.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,590,684,100.00	2,326,319,250.15	264,364,849.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,415,810,300.00	2,159,226,750.15	256,583,549.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,756,596,100.00	1,543,756,252.00	212,839,848.00
210101	Үндсэн цалин	1,345,950,500.00	1,130,823,498.00	215,127,002.00
210102	Нэмэгдэл	391,513,400.00	356,258,359.00	35,255,041.00
210104	Урамшуулал	19,132,200.00	56,674,395.00	-37,542,195.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	219,529,700.00	190,886,018.15	28,643,681.85
210201	Тэтгэврийн даатгал	149,280,300.00	130,368,610.19	18,911,689.81
210202	Тэтгэмжийн даатгал	17,400,900.00	15,520,006.82	1,880,893.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,211,300.00	12,416,003.64	1,795,296.36
210204	Ажилгүйдлийн даатгал	3,512,500.00	2,821,627.04	690,872.96
210205	Эрүүл мэндийн даатгал	35,124,700.00	29,759,770.46	5,364,929.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	182,902,000.00	182,389,260.00	512,740.00
210301	Гэрэл, цахилгаан	31,650,500.00	31,470,760.00	179,740.00
210302	Түлш, халаалт	119,900,000.00	119,567,000.00	333,000.00
210303	Цэвэр, бохир ус	31,351,500.00	31,351,500.00	0.00
2105	Нормативт зардал	68,769,300.00	57,474,751.00	11,294,549.00
210502	Хоол, хүнс	68,769,300.00	57,474,751.00	11,294,549.00
2106	Тавилга	6,983,000.00	6,983,000.00	0.00

210602	Урсгал засвар	6,983,000.00	6,983,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,722,800.00	22,701,770.00	21,030.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,325,700.00	5,325,700.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,397,100.00	17,376,070.00	21,030.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	158,307,400.00	155,035,699.00	3,271,701.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	132,211,800.00	128,940,099.00	3,271,701.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,095,600.00	26,095,600.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	174,873,800.00	167,092,500.00	7,781,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	174,873,800.00	167,092,500.00	7,781,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	174,873,800.00	167,092,500.00	7,781,300.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,590,684,100.00	2,590,171,360.00	512,740.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,299,253,700.00	2,299,253,700.00	0.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,299,253,700.00	2,299,253,700.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	281,074,700.00	280,561,960.00	512,740.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	281,074,700.00	280,561,960.00	512,740.00
12	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,355,700.00	10,355,700.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,325,700.00	5,325,700.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,030,000.00	5,030,000.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	263,852,109.85	-263,852,109.85

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	3,864,458.00	-3,864,458.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	3,864,458.00	-3,864,458.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	3,375,000.00	-3,375,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	3,375,000.00	-3,375,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	3,375,000.00	-3,375,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	489,458.00	-489,458.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	489,458.00	-489,458.00

213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	0.00	489,458.00	-489,458.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	3,864,458.00	-3,864,458.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	3,375,000.00	-3,375,000.00
131101	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	3,375,000.00	-3,375,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	489,458.00	-489,458.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	0.00	489,458.00	-489,458.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ховд аймгийн Жаргалант сумын 7 дугаар сургууль нь сургууль, багш, эцэг эхийн хамтын ажиллагааг өргөжүүлж сурагчдын, сурлага, хөгжил төлөвшилд ахиц гаргаж, хүнлэг энэрэнгүй иргэнийг төлөвшүүлнэ” гэсэн эрхэм зорилгын хүрээнд 2022 оны хичээлийн жилийг “Сургууль, багш, эцэг эхийн хамтын ажиллагааг өргөжүүлж, сурагчдын сурлага, хөгжил төлөвшилд ахиц гаргаж, хүнлэг энэрэнгүй иргэнийг төлөвшүүлнэ” гэсэн зорилго дэвшүүлэн ажиллаж байна. Энэхүү зорилгынхоо хүрээнд “Эрүүл бие бялдартай хүүхдийг төлөвшүүлж эрүүл зөв дадлыг хэвшүүлнэ”, “Зөв эерэг хандлагатай хүүхдийг төлөвшүүлнэ”, “Мэдлэгээ хэрэглээ болгоход анхаарч бүтээлч хүүхдийг төлөвшүүлнэ” гэсэн тэргүүлэх зорилт тавин ажиллажээ.

Тус сургууль нь сургуулийн захирал – 1, сургалтын менежер – 3, нийгмийн ажилтан – 1, бага дундын 63 багш, үйлчилгээний албан хаагч - 43, нийт 111 багш ажиллагсадтайгаар сургалт хүмүүжлийн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус сургууль нь 2023 оны эхний улирлын байдлаар бага ангийн-23, дунд, ахлах ангийн-42 багштай. Тэргүүлэх 28, заах аргач 25, зэрэггүй 10 нийт багш нарын 84% нь мэргэжлийн зэрэгтэй, 1 багш дипломын, 9 багш магистр, 54 багш бакалавр зэрэгтэй байна.

Багшлах бүрэлдэхүүнийг ажилласан жилээр авч үзвэл 1-5 жил ажилласан 13 багш – 20,3%, 6-10 жил ажилласан 13 багш - 20,2%, 11-20 жил ажилласан 33 багш – 51,5%, 20-иос дээш жил ажилласан 4 багш- 8%-ийг эзэлж байгаа нь нийт багшлах бүрэлдэхүүний 70% нь 1-15 жил ажиллаж байгаа залуу багш нар байна.

2022 онд хийсэн багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр II түвшний багш -1, III түвшний багш -1, IV түвшний багш 2 шалгагдсан байна.

Жаргалант сумын 7 дугаар сургууль нь 320 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай бөгөөд 2022-2023 оны хичээлийн жилд 152 хүүхэд шинээр элсэж, нийт 46 бүлэгт 1456 сурагч суралцаж, бага анги буюу 1-5 дугаар ангийн 22 бүлэгт 806, дунд анги буюу 6-9 дүгээр ангийн 16 бүлэгт 462, ахлах анги буюу 10-12 дугаар ангийн 7 бүлэгт 188 сурагч суралцаж байна. Нийт шилжиж ирсэн 35, шилжиж явсан 50 сурагч байна.

2022 онд дотуур байранд 94 хүүхэд амьдарч хоолны зардалд 16377 хүүхэд өдөр 56.9 сая төгрөг, үдийн хоолонд бага ангийн 22 бүлэгт 112,210 хүүхэд өдөр суралцаж үдийн хоолны зардалд 167.1 сая төгрөгийг зарцуулжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд 2022 онд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. 2022 онд Боловсролын тухай хуульд 3 удаа, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд 2 удаагийн өөрчлөлт оржээ.

Боловсролын байгууллагын багш ажилтанд үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл олгох журмуудад өөрчлөлт орсон байна. 2022 онд боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах, багшийн хөгжлийг дэмжих, цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах журмыг шинээр баталжээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.

2022 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу Жаргалант сумын 7 дугаар сургуулийн даргын 2022 оны 05 дугаар сарын 03-ны А/29 дүгээр тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулж хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдалд хяналт тавих ажлуудыг зохион байгуулсан байна. Тооллогоор 13 нэр төрлийн 21 ширхэг ашиглалтгүй хөрөнгийг актлуулах саналыг хүргүүлсэн байна.

Сургуулийн дотоод хяналтын ажлын хэсэг 2022 онд 10 ажил хийхээр төлөвлөгөө гаргаж дотуур байрны эрсдэлийн үнэлгээ, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээний журмын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, сургуулийн дотоод галлагааны зууханд хяналт үнэлгээ зэрэг ажлуудыг хийжээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын 7 дугаар сургууль нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жаргалант сумын 7 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 307.2 сая төгрөгөөр буюу 6.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	263,852.1	263,852.1
Авлага	13,599.5	30,133.2	16,533.7
Бараа материал	124,704.8	158,465.0	33,760.2
Үндсэн хөрөнгө	4,964,562.6	4,957,666.4	(6,896.2)
Нийт хөрөнгө	5,102,866.8	5,410,116.6	307,249.8
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,102,866.8	5,410,116.6	307,249.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,102,866.8	5,410,116.6	307,249.8

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25 өдрийн 18 дугаартай албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 263.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- 2021 оны эцэст 13.6 сая төгрөгийн авлагатай байсан. “Цахим засаглал” үндэсний хөтөлбөр, “Ховд аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасны дагуу ерөнхий боловсролын сургуулиудад сүүлийн үеийн цахим технологи ашиглан сургалт явуулах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор Санко маркетинг монголиа ХХК-иас ухаалаг дэлгэцийг худалдан авахад 13.0 сая төгрөгийг шилжүүлж авлагад бүртгэсэн. 2022 онд ухаалаг самбарыг хүлээн авч данс бүртгэлд тусгаж авлагыг барагдуулсан байна.
- 2022 оны эцэст 29.6 сая төгрөгийн авлагатай байна. Саммит компьютер технологи ХХК-аас 25.6 сая төгрөгийн ухаалаг самбар, суурин компьютер хугацаандаа багтаж ирээгүй, цахим хуудас хийлгэхээр 0.5 сая төгрөгийг шилжүүлсэн боловч цахим хуудсыг хүлээн аваагүй, хүн амын орлогын албан татварын авлага 4.0 сая төгрөгийг илүү тооцон шилжүүлсэн тул авлагад бүртгэсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,135.7 сая, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 10.3 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2,065.3 сая төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 398.3 сая төгрөгөөр, зардлыг 399.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн батлагдсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны орон нутгийн батлагдсан төсвийг 118.4 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,299.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 10.3 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 281.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийт 2,590.7 сая төгрөгийг бүрдүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,299.3 сая төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 10.3 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 281.1 сая төгрөг, нийт 2,590.7 сая төгрөг бүрдүүлж, нэмэлт санхүүжилтээр 3.9 сая төгрөг бүрдүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,326.3 сая төгрөг 90.0 хувьтай байгаа бөгөөд 0.5 сая төгрөгийг төвлөрүүлж дансны үлдэгдэл 263.9 сая төгрөг байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	/мянган төгрөгөөр/		
			Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Ерөнхий боловсрол / байр ашиглалт 71802/80226	6,958.80	6,958.80	0.00	100%
2	Ерөнхий боловсрол / сургалт семинар 71802/80312	3,479.40	3,479.40	0.00	100%
3	Ерөнхий боловсрол / эрүүл мэндийг дэмжих 71802/81605	8,002.70	4,731.00	3,271.70	59%
4	Ерөнхий боловсрол / үдийн цай 71802/81801	174,873.80	167,092.50	7,781.30	96%
5	Ерөнхий боловсрол / дотуур байрны хүүхдийн хоол 71802/81806	117,129.80	98,380.70	18,749.10	84%
6	Ерөнхий боловсрол / зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр 71802/81816	80,920.00	80,920.00	0.00	100%
7	Ерөнхий боловсрол / боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх 71802/81823	15,657.40	15,657.40	0.00	100%
8	Ерөнхий боловсрол / боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 71802/81834	1,709,963.50	1,535,126.50	174,837.00	90%
9	Ерөнхий боловсрол / сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах 71802/81835	182,268.30	123,055.30	59,213.00	68%
10	Ерөнхий боловсрол / гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчныг сайжруулах 71802/81844	2,580.00	2,580.00	0.00	100%
11	Ерөнхий боловсрол / Сурах бичгийн түрээс 71802/81848	5,325.70	5,325.70	0.00	100%
12	Ерөнхий боловсрол / ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан 71802/83602	2,450.00	2,450.00	0.00	100%

13	Ерөнхий боловсрол / Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал 71802/80111	189,885.00	189,372.26	512.74	100%
14	Ерөнхий боловсрол / Нийтлэг үйлчилгээ 71802/80112	91,189.70	91,189.70	0.00	100%
ДҮН		2,590,684.1	2,326,319.3	264,364.8	90%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 0.5 сая төгрөг, сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр 5 төслийн үлдэгдэл 3.4 сая төгрөг, аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас багш нарын замын зардалд 3.4 сая төгрөг, нийт 3.9 сая төгрөгийг бүрдүүлж, үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Ховд аймгийн Жаргалант сумын 7 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор Ц.Бадрал 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс 02 дүгээр сарын 16-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 14 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,384.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 35.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн

материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 25.0 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Ховд аймгийн Жаргалант сумын 7 дугаар сургууль нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тэргүүн дэд, дэд, орлогч дарга, 6 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгсэл, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 10 дугаар зүйлд заасан цалин хөлс, нэмэгдэлтэй холбоотой заалтууд хамаарахгүй байна.

8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцас, 11 дүгээр зүйлд заасан нэг удаагийн мөнгөн тэтгэмж, 13 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой ямар нэгэн зардал гараагүй байна.

9 дүгээр зүйлд заасан албан томилолтын зардалд 0.2 сая төгрөг зарцуулсан ба энэ нь 1 багшийн улсын олимпиадад оролцох замын зардалд зарцуулсан байна.

12 дугаар зүйлд заасан бусад хангамжтай холбоотой гар утасны зардалд 4.0 сая төгрөгийн зардал гарсан ба энэ нь багш нарын дата хэрэглээнд Боловсрол шинжлэх ухааны сайдын баталсан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах журмын дагуу зарцуулагдсан байна.

14 дүгээр зүйлд заасан цахим худалдан авалтын хүрээнд 88.5 сая төгрөгийн таблет, зөөврийн компьютер, ухаалаг самбар, программын эрх, суурин компьютерын худалдан авалт хийгдсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс хугацаандаа оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо нийлж баталгаажуулаагүй, үдийн цайны зардлаас Бүрэгтэй ХХК-ны харилцах данс руу нэхэмжлэлээс илүү дүнгээр шилжүүлсэн 331.5 мянган төгрөг, Засгийн газрын шагналаар шагнагдсан албан хаагчдад 318.6 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон зөрчилд төлбөрийн акт, түлш халаалтын зардлаас

нүүрс бэлтгэхдээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, анхан шатны баримтын бүрдэлгүй, шаардах хуудасгүй ажил гүйлгээг бүртгэлд тусгасан 116,630.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, байгууллагын нүүрсний бодит зарцуулалтыг хянах зорилгоор ажлын байрны зураг авалт хийхэд дутуу шатсан нүүрс ихтэй үнсийг зайлуулсан ба түүнийг нь ойр орчмын иргэд ачиж авахдаа нүүрстэй хамт авсан байж болзошгүй үйлдэл илэрсэн, нүүрсний зарцуулалт хэт үрэлгэн, тог, ус тасарсан гэж дотоод хяналтын тайланд бичигдсэн ч Шим-Ус ОНӨААТҮГ, Цахилгаан түгээх сүлжээ ХХК-с тодруулахад тухайн хугацаанд тог, ус тасраагүй болохыг нотолж ирүүлсэн, баталсан орон тоог 1-ээр нэмэгдүүлсэн, батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй 153,701.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд зөвлөмж өгч, тайлант оны элэгдлийн зардал болон тайлант үеийн үр дүн зөрүүтэй тайлагнасан, байгууллагын түлш халаалтын зардлаас нүүрс худалдан авч ажилчдад түлээ, нүүрсний тусламж олгон түлш халаалтын зардлаар тайлагнасан 2,325.0 мянган төгрөгийн алдаа илэрснийг залруулжээ.

Актын төлбөрийг бүрэн барагдуулж, нүүрстэй холбоотой өгөгдсөн зөвлөмжийн хүрээнд энэ онд өдөрт дунджаар 3 тонн нүүрсний зарцуулалттай байна. Дотоод хяналтын ажлын тайланд 2 өдөр Аудитын газраас хамтран хяналт хийхэд галлагаанд ид ачааллын үеэр өдөрт дунджаар 5 орчим тонн нүүрс зарцуулж байсан талаар дурдсан байна. 2022 онд хамгийн их ачаалалтай үедээ 4.2 тонн, хамгийн бага ачааллын үед 2 тонн нүүрсийг 1 өдөрт дунджаар зарцуулжээ.

Өгөгдсөн албан шаардлагын хүрээнд анхан шатны баримтын бүрдлийг хангаж, нүүрс худалдан авах гэрээг байгуулан ажиллажээ.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	650.1	1	650.1	100
Албан шаардлага	1	116,630.5	1	116,630.5	100
Зөвлөмж	2	153,701.1	2	153,701.1	100
Нийт дүн	5	270,981.7	5	270,981.7	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Саммит компьютер технологи компанид ХОАЖЕБС7/004/001, ХОАЖЕБС7/003/002 тоот гэрээнүүдийн дагуу 5 ширхэг компьютер, 1 ширхэг ухаалаг самбарын үнэ 25.6 сая төгрөгийг шилжүүлэн цахим худалдан авалт хийснээс хөрөнгө ирээгүй авлагаар бүртгэсэн байгааг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 0.5 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 0.5 сая төгрөгийн алдааг залруулав.

Үүнд: Байгууллагын албан ёсны цахим хуудсыг шинээр хийлгэхээр гэрээ байгуулан урьдчилгаа мөнгийг шилжүүлсэн бөгөөд цахим хуудсыг албан ёсоор хүлээн аваагүй, шууд зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д "Нягтлан бодох бүртгэлийн алдааг гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

залруулна", Сангийн сайдын 2021 оны 190 тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй байгаа тул залруулж бүртгэв.

Аудитаар нийт 10.1 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 4.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 5.6 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

Тус байгууллагын нүүрстэй холбоотой асуудал хуулийн байгууллагад шалгагдаж байна.

5.1 Төлбөрийн акт

- 2022 онд 1 ажилтны цалин хөлсийг эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүйгээр, тогтоосон хэмжээнээс нэмэгдүүлэн тогтоож 0.5 сая төгрөгийг илүү тооцон олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/122 тоот тушаалын 1 дүгээр хавсралт, Жаргалант сумын Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/134 дүгээр захирамжийг зөрчсөн тул акт тогтоов.
- 2022 онд цалингийн зардлаас хувь хүний орлогын албан татварт илүү шилжүүлэн авлага үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ." гэсэн заалтыг зөрчсөн тул акт тогтоов.

5.2 Зөвлөмж

1. Түлшний хөнгөлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус сургууль нь 2022 онд 52 багш, ажилтанд 5.0 сая төгрөгийн үнэ бүхий 26 тонн нүүрс олгосон бөгөөд түлш халаалтын зардалд тусгасан нь Сангийн сайдын 2021 оны 190 тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланд зардлын эдийн засгийн ангиллыг үнэн бодитоор тусгах, Сангийн сайдын 2021 оны 190 тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын дагуу холбогдох зардалд тусгах.

2. Санхүүгийн анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

2022 онд биеийн тамирын багш нарын чуулга уулзалтад оролцоход гарсан замын зардал /шатахуун/-д 0.2 сая төгрөг, сурагчдын дунд явуулсан "Хөдөлгөөн эрүүл мэнд", "Номтой нөхөрлөө" зэрэг уралдаантай холбоотой 0.4 сая төгрөгийн зардлын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, уралдааны удирдамж, уралдаан явуулсан тайлангаас өөр санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл хангагдаагүй байна.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангах, бүрдэлгүй ажил гүйлгээг санхүүгийн тайланд тусгахгүй, зардлыг санхүүжүүлэхгүй байх.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Запруулсан		Запруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Данс бүртгэлд буруу тусгасан	1	500.0			1	500.0	1	500.0				
Дүн	1	500.0			1	500.0	1	500.0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан туш	Тоо	Дүн
Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл хангагдаагүй	3	567.0					3	567.0	0	0	0	0
Зардлын зүйл анги зөрчин тайлагнасан	1	5,070.0					1	5,070.0				
Үндсэн цалинг тушаал шийдвэргүйгээр нэмэгдүүлэн тогтоосон.	1	490.1	1	490.1	0	0						
Цалингийн хэмнэгдсэн зардлыг илүү шилжүүлэн авлага үүсгэсэн	1	4,001.2	1	4,001.2								
Дүн	6	10,128.3	1	4,491.3	0	0	4	5,637.0	0	0	0	0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:

Б.БОЛДБААТАР

А.ЦЭЦЭГСҮРЭН

Ц.БАДРАЛ